



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2023/39/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг:
tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг:
erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор Ж.Бүжинханд
Утас: 99177546 Цахим хаяг:
Bujinkhandj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА Д.СЭЛЭНГЭ
ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.24 № 89

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны зардлын тодорхой хэсгийг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хэлбэрт шилжүүлсэн байна.

Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, төлбөрийг нь санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн багц, төлбөрийн хэмжээг тогтоосон “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай” Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол” 2022 оны 06 тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан байна.

Тайланд онд төсвийн хөрөнгөөр 18.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэж, 4,213.7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 23 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 78 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 92.8 хувийн биелэлттэй байна. Эрүүл мэндийн газраас гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнээгүй байна.

0702000108

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

		/мянган төгрөг/	
	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,719,361.7	1,692,616.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	18,191,109.9	20,583,656.5
	Нийт хөрөнгийн дүн	20,910,471.6	22,276,273.2
	Нийт өр төлбөрийн дүн	1,128,132.9	812,885.8
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	19,782,338.8	21,463,387.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	20,910,471.6	22,276,273.2
	Үйл ажиллагааны орлогын дүн	16,301,794.8	15,295,847.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	12,932,672.6	13,500,609.4
	Үйл ажиллагааны үр дүн	3,369,122.1	1,795,237.7
	Үйл ажиллагааны бус үр дүн	(2,333.0)	(107,779.0)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	3,366,788.8	1,387,458.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,416,076.6	19,782,338.8
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		284,613.6
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-526.6	-291,023.5
	Тайлант оны үр дүн	3,366,788.8	1,687,458.7
	Эцсийн үлдэгдэл	19,782,338.8	21,463,387.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	9,280,187.8	11,200,270.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	9,257,790.2	11,186,107.6
	Үйл ажиллагааны ЦМГ	22,397.6	14,163.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	12,358.5	18,127.9
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	10,039.1	-3,964.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,039.1	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6,074.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		
	Урсгал зардал	11,948,473.7	11,204,235.5
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	11,942,736.3	11,200,245.4
	Эрүүл мэндийн даатгалаас санхүүжих	11,567,736.3	10,660,250.7
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	0	6,074.5

Гурав. Аудитын илрүүлэлт: Аудитаар нийт 33.8 сая төгрөгийн алдаа¹, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн 32.8 сая төгрөгийн гүйлгээг аудитын явцад гүйлгээг нөхөн шивүүлж, зөрчлийг арилгасан. Үүнд:

- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Мөнгөн гүйлгээний тайлан орлого, зардлыг 1.0 сая төгрөгийг зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах,

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

- ✓ **Хууль тогтоомжтой холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 32.8 сая төгрөгийн гүйлгээг системд нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 188.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 3.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 10 заалт албан шаардлага, 185.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас ажлын хөлс, өндөр насны тэтгэвэрт гарсан ажилчдад бэлэг дурсгал, эрдэм шинжилгээний бага хурлын шагнал, сургалтын цайны зардал, төрийн болон яамны шагналын дагалдах шагналын 3.2 сая төгрөгийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т "нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах;" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага

- ✓ Тайлант онд тэтгэвэрт гарсан 10 албан хаагчийн дуусгалын тооцоог хийгээгүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т "Ажил олгогч ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах тохиолдолд ажлыг нь түр, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд бүрмөсөн хүлээн авна", 110 дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.8-т "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох; ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд 156.6 сая төгрөгийг дутуу шивсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Тендерт шалгараагүй аж ахуйн нэгж байгууллагаас 5.2 сая төгрөгийн бичиг хэрэг, хоол, цэвэрлэгээний материал худалдаж авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" заалтыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Ажилчдын цалингаас хуримтлал нэрээр 2.3 сая төгрөг, хариуцлагын даатгал 3.2 сая төгрөгийг суутгасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-т "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно: 119.1.1.ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг ажилтнаар нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан; 119.1.2.шүүхийн, эсхүл хөдөлмөрийн эрхийн маргаан шийдвэрлэх байгууллагын шийдвэр хүчин төгөлдөр болсон; 119.1.3.ажилтанд энэ хуулийн 123.2.3-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан; 119.1.4.хууль тогтоомжид заасан бусад тохиолдол" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Тээвэр шатахууны зардлыг 1.3 сая төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 10.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Авлага, өглөг үүсгэлгүйгээр 2021 оны 0.4 сая төгрөгийн томилолт, 3.9 сая төгрөгийн илүү цагийн хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар бүлгийн 2-т "Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны дараа сарын цалин хөлстэй хамт тооцож олгоно" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Данс бүртгэлд нэгээс дээш жилийн насжилттай 23.9 сая төгрөгийн авлага, 812.8 сая төгрөгийн өглөг, шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын 1.2 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж,

баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Өндөр насны тэтгэвэрт гарах ажилчдад 4 дүгээр улирлын урамшууллыг 3 дугаар улиралд 1.1 сая төгрөгийг урьдчилан олгосон нь "Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3 дугаар зүйлийн 3.2-т "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас зардлын эдийн засгийн ангилал зөрчиж сургалтын зардал, тасгийн нээлтийн үйл ажиллагааны морин хуурч, хөтлөгчийн ажлын хөлс, дугуйны үнэ төлсөн зэрэг 0.9 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

- ✓ Илрүүлэлт: Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 6 дугаар зүйл "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар олгох арга хэмжээг 2022 онд багтаан зохион байгуулах, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 1-т "Автомашин хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай"-ийн дагуу авто тээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугааргүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын эзэмшиж ашиглаж байгаа автотээврийн хэрэгслийг тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугаартай болгох,
Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.
Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

				Үүнээс	Зөвлөмж
--	--	--	--	--------	---------



Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг	2	33.8	1	32.8	1	1.0	2	33.8	-	-	-	-
Дүн	2	33.8	1	32.8	1	1.0	2	33.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг	8	26.8	1	2.3	7	23.5	-	-	-	-	-	-
Дүн	8	26.8	1	2.3	7	23.5	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг	3	-	-	-	2	161.8	1		
Нийт дүн	13	161.8	-	-	2	161.8	1		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	1	-	-	-
	НИЙТ	1	1	-	-	1	-	-	-

